

МОНСУДАР

**МОНГОЛ БИЧГИЙН
ЗӨВ БИЧИХЗҮЙН
ТОЛЬ**

(ШИНЭЭР ЖУРАМЛАСАН ТОЛЬ)

Монгол хэл соёл

5

“МОНСУДАР” хэвлэлийн газар

**МОНГОЛ БИЧГИЙН ЗӨВ
БИЧИХЗҮЙН ТОЛЬ**

**Нямсүрэнгийн ДАШ
Бямба-Очирын ОДОНЧИМЭГ
Содномын ЧУЛУУНШҮРЭВ**

Редактор Г.Сүлд-Эрдэнэ

**Улаанбаатар
2012 он**

DDC

494.23'81'03

Д- 392

Монгол Бичгийн Зөв Бичихзүйн Толь Анхны хэвлэл

Толийг бүтээгч: Н.Даш

Б.Одончимэг

С.Чулуунпүрэв

Хамтран ажилласан мэргэжилтэн:

Ш.Чоймаа (Sc.D)

С.Баярсайхан (Ph.D)

Э.Мөнх-Учрал (Ph.D)

С.Батхишиг (Ph.D)

Редактор: Г.Сүлд-Эрдэнэ

Эх бэлтгэл: Ж.Амгалан

Хавтасны дизайн: Б.Баясгалан

Зохиогчийн эрх © 2012 “МОНСУДАР” хэвлэлийн газар

Бүх эрх хуулиар хамгаалагдсан болно. Энэхүү номын эхийг хэвлэлийн газрын зөвшөөрөлгүйгээр хэсэгчлэн болон бүтнээр дахин хэвлэх, хайлтын системд байршуулах, цахим, механик, фото хуулбар зэрэг ямар ч хэлбэрээр хувилж олшруулах, түгээн тараахыг хатуу хориглоно.

“МОНСУДАР” хэвлэлийн газар

АДМОН ХХК-ийн байр, Амарын гудамж 2

Хаяг: Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14200

Утас: (976 11) 329962

Факс: (976 11) 327251

Э-мэйл: info@monsudar.mn

Вэбсайт: www.monsudar.mn

ISBN 978-99962-0-598-9

АДМОН компанид хэвлэв.

ӨМНӨТГӨЛ

I

Хүмүүн бээр хэлээр дамжуулан ургуулан бодож, нэгтгэн дүгнэдэг. Өөрөөр хэлбэл хэлээр сэтгэдэг болой. Хэл бол сэтгэлгээний багаж юм.

Өөр өөр хэл гэдэг бол өөр өөр сэтгэлгээ буюу ертөнцийг өөр өөр үзэхүй байдаг. Харин ертөнцийг өөр өөрөөр үзэхүйн үр, тусгал хэлбэр нь өөр өөр үндэстний соёл амуй. Иймд хэл бол зүгээр нэг бидний өдөр тутмын харилцааны үхмэл хэрэглүүр бус сэтгэлгээг бүтээгч амьдлаг шинжтэй үйл явц, соёлыг бүрэлдүүлэгч хамгийн гол хүчин зүйл юм. Товчхондоо «Хэл = Сэтгэлгээ = Соёл» буюу үндэстний соёл гэдэг бол үндэстний хэлнээс үүдэн тогтнож байдаг зүйл гэж үзүүштэй. Хэлний хувьд нэгдмэл байх нь үндэстэн бүрэлдэхийн үндэс юм.

Иймээс хэл бол улсын тусгаар тогтнохуйтай шууд холбоотой зүйл болой.

II

Билгүүн номч Б.Ринчений “Монгол хэл” шүлгийн

“Урьдын бэрх цагт улс Монголын хэт заяаг

Уйтгарлан бодоход урам зоригийг минь сэргээсэн

Өөдлөн дэгжихийн төгс хувьтайд нь итгүүлсэн

Өрнөн мандахын шинж бүрдсэн өвгөдийн минь хэл”

гэсэн бадгийн хэл гээч улсын хэт заяа өөдлөн дэгжих, өрнөн мандахтай юуны хамаатай байдгийг чухам дээрхээр ухахад яг сайхан таарах билээ. Мөн шүлэгт гардагчлан монголчууд бид хөгжим мэт яруу баясгалант аялгуу сайхан монгол хэлтэй, түүндээ тохирсон үндэстний бичиг соёлтой үндэстэн. Энэ үндэстний бичгээ лавтайяа 1000 жилийн өмнөөс хэрэглэсээр иржээ. Энэ явцад монгол бичиг монгол хэлний авиа зүй, авиалбарын ёсонд бүрнээ нийцэн, монгол хэлний үг бүтэх ёсон, эгшиг зохицох ёсонд тохирон, монголын бүхий л түүх соёлыг нэвт шингээсэн, бүхий л түүх соёлд нэвт шингэсэн оюуны их өв болжээ. Монгол бичиг урт удаан оныг даван үеэс үед боловсрон хөгжсөөр монгол хэлэнд яв цав тохирсон, эргээд монгол хэл, монгол соёл, монгол хүмүүний сэтгэлгээг тэжээн тэтгэсээр ирсэн бичиг болохыг 1941 онд монгол бичгийг халж шинэ үсэг хэрэглэх болсноос хойш гүнээ мэдэрсэн ажгуу.

Монгол хүний ам зөрж байгаа нь ч гадаадын хүнд ямархан нэгэн чихнээ чимэгтэй аялгуу үүсгэн байгаа мэт сонсогддог тухай дурдсан байдаг билээ. Тиймдээ ч “чихний чимэг болсон, хөгжим мэт яруу баясгалант, аялгуу (эгшиг) сайхан монгол хэл” хэмээсэн байнам. Энэ бол монгол хэлний үгийг монгол бичгээр тэмдэглэж хэлэлцдэг асан цагийн тэмдэглэл ажээ. Үүнээс хойш 1990-ээд он гэхэд монгол хүний хэлэлцэж байгаа нь ч хэрэлдэж байгаа шиг хар яр гэж хавиралдсан сонсголонгүй болсон гэжээ. Энэ бол хэлнийхээ авиан зүйн ёсонд зохирсон бичгээ үл тохирох үсгээр сольж, бичсэнээрээ уншиж, хэлэлцэх болсноор шинэ үсэгт монгол хэлний авиан зүй эвдэрснийг хэлж байх нэгээхэн жишээ.

Шинжлэх ухааны доктор, профессор Ш.Чоймаа багшийн хэлснээр “Монгол бичиг он жилийн уртыг туулан боловсорч ирэхдээ эрт цагийн үгийн бүтцийг өчүүхэн ч алдагдуулахгүйгээр бидэнд хүргэж авчирсан нь чухамдаа монгол хэлний хөгжил хувирал бүхнийг ташаагүй үнэн тэмдэглэсэн түүхэн сурвалж бичиг мэт амой.” Өөрөөр монгол бичиг бол монгол туургатны аялгуу бүрийн онцлогийг алдагдуулдаггүйгээрээ монгол олон аялгуутны соёлын нэгдлийн цөм нь мөн. Монгол бичиг ба монгол хэл, сэтгэлгээ, соёлын шүтэлцээг цаашид зүйл бүрт өгүүлж болох ч үүнээс нэгэн чухлыг дүгнэж болох нь монгол

бичиг мөнөөхөн улсын тусгаар оршихуйн үндэс болсон монгол хэлний бат оршихуйн амин шүтэлцээ нь юм.

Иймээс монгол бичиг бол монгол улсын оршихуйг батжуулагч нь болой.

III

Түүхийн олон туршлагаас харахад ямар нэг улсыг эзлэн дарангуйлагчид хамгийн түрүүн бичиг үсгийг нь үгүй хийж, дороо эрхшээн номхруулж байсан байх юм. Ерөөс аль ч улс орны бичиг үсэг нь он цагийн уртад тэр ард түмний хэлний онцлогт чанд нийцэн зохицсон соёлын чухал нэгж болсон байдаг учир хэлний зүйгээ чанд хадгалсан бичгийг нь үгүй хийж өөрсдийн үсэг бичигт оруулахад тухайн соёлын нөлөөнд автан хэл нь мөхөж, хэлээ алдсан үндэстэн өөрийн үндэстний өвөрмөц сэтгэлгээгээ алддаг байна. Соёл гэдэг бол тухайн үндэстний өвөрмөц сэтгэлгээнийх нь тусгал, сэтгэлгээнээс нь үүдсэн үр дүн байдаг учраас хэлээ алдвал соёлоо шууд алдана гэсэн үг юм. Ингэсэн цагт тэр улсыг тусдаа үндэстэн, тусгаар улс гэж хэлэхэд чухам л бэрх болох билээ.

1941 оны монгол бичгийг халж шинэ үсэг хэрэглэсэн явдал бол үнэндээ монголчуудын хэл, сэтгэлгээг нь мохоон соёлоор дагуулах гэсэн нэг л бодлого байсан гэж үзэхэд нэг их гажаад байхгүй л биз ээ. Эдүгээ монгол хэлний мөн чанараараа оршин тогтнохуйг тойрсон олон асуудал тулгамдсан нь дээрх бодлогын хэрэгжил сайн байгаагийн илрэл гэлтэй. Гэтэл бид өнөөдөр ч хэн нэгний хараат эрхшээлд байгаа мэтээр мөнөөх бодлогыг үргэлжлүүлсээр байгаагаа сэхээрч нэг харах цаг нь болсон баймаар.

Даяаршил хэмээгч даяараа нэг зүйлд зангилагдахын нэр, их гүрний эрхшээн дагууллын орчин цагийн боловсон хэлбэр бөгөөтөл бид цагийн цавиргаа, даяаршлын давалгаанд нэгэнт автсаны горьг заххаас нь амсаад эхэлжээ. Өмнө ярьсан хэл-сэтгэлгээ-соёлын гурвалсан ойлголтыг түшиглэсэн, колони орны боловсролын тогтолцоог чиг шугамаа болгон хэл-сэтгэлгээ бүдэгрэн доройтохын эхлэлийг тавьж буй тодорхой нэгэн жишээ бэлхнээ бий болоотохсон байна.

IV

Нэг үеэ бодоход монголчуудын үндэстний ухамсар нэлээд сэргэжээ. Нэгээхэн жишээ болгож өнгөрсөн 2011 онд онцлон тэмдэглэсэн олон ойннуудыг дурдахад л өөр олон зүйл нурших шаардлагагүйгээр бараг тодорхой харагдана. Хүннү гүрэн байгуулагдсаны 2220 жилийн ой, Их Монгол улс байгуулагдсаны 805 жилийн ой, Үндэсний эрх чөлөөний хувьсгал ялсны 100 жилийн ой, Ардын хувьсгалын 90 жилийн ой гээд үндэсний бахархалт ойннуудыг өргөн дэлгэр тэмдэглэж өнгөрөөлөө. Тун саяхны өмнөхтэйгөө харьцуулахад үндэсний үзэл ухамсар гайхмаар ихээр сэргэжээ. Өнгөрснөөрөө бахархах гэдэг өөрийн үндсэрхэг сэтгэлгээ, эх оронч үзлийг батжуулсан сайн зүйл боловч бид ирээдүйд бахархах зүйл үлдээхийн төлөө юу хийж байгаа сан билээ. Бүтээхийг байя гэхэд бүтээсэн юмаа үгүй хийхгүй байхыг давхар бодох ухамсарлал байх ёстой буй за.

Үндсэрхэг үзэл, эх оронч үзэл хоёрыг ялгаж салгаж ойлгох цаг нь болжээ. Бид хэдий болтол юмны цаад учир холбогдлыг ухаж бодолгүйгээр зүгээр нэг, юмыг цээжээ дэлдэх символ хэлбэрээр нь харах вэ? Өвөг дээдсээс үлдээсэн дэлхийд ганцхан босоо монгол бичиг гэж омогшиж бардамнах, түүгээрээ гайхуулах, дэлхийд сурталчлах гэж ярихаас цааш бид юуг хийсэн билээ. Мэдээж энэ бол бидний монголчуудын юм, бидний өвөг дээдсийн өвлүүлсэн өв учир бахархах, хайрлах нь зүй. Гэвч үүний цаана бидний тусгаар оршихуйн үндэс буй гэж ухаж эх оронч үзлээр ханддаг нь хэд л бол доо.

Монгол улс тусгаар улс хэдий ч өмнөх нийгмийн үед гадны улсын эрхшээлээр үсэг бичгээ гэсэн бодлогыг өнөөдөр ч үргэлжлүүлсээр байгаа нь харамсалтай. Гэхдээ үе үеийн төр засаг үндэсний бичгийнхээ төлөө бодлого шийдвэр гаргасаар ирснийг дурдах хэрэгтэй. Үүний дотроос Монгол улсын дөрөв дэх ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн монгол бичгийн албан хэрэглээг нэмэгдүүлэх зарлиг болбоос үндэсний бичгээр дамжуулан эх орныхоо төлөө хийсэн томоохон үйл байсныг онцлууштай. Энэчлэн монгол бичиг юүгээн сэргээн монгол төрийн бичиг болгон хэрэглэх түүхэн ач холбогдолт шийдвэр хэрэгтэй буйг нэмэн тэмдэглэсү. Монгол бичиг соёлын төлөө буюу монгол улсын эрх ашгийн төлөө амьдралаа зориулсан монголын бичгийн их хүмүүн, нэрт эрдэмтэн Чой.Лувсанжав багштаны үгээр энэ удаад үгээ өндөрлөхөд:

Энэ их хэрэг бол монгол үндэстэн, соёлын эрх ашгийн төлөөний хэрэг тул энэ хэргийг сэтгэлийн хөөрөл, хорхойсол, шохоорхол мэт үзвээс даруй эндүүрэл болмой.

МОНГОЛ БИЧИГ БОЛ МОНГОЛ ӨВ СОЁЛЫН ГОЛОМТ МӨН.

С.Чулуунпүрэв

2012 оны 5 дугаар сар 31

УДИРТГАЛ

Монгол бичгийн гарал үүсэл

“Ном гэдэг үнэхээрийн гайхамшиг!... Хүн төрөлхтөн өөрийн ухамсарт бүх түүхийнхээ турш номоос илүү гайхуулам ид шидтэй юм бараг бүтээгээгүй болов уу гэж би бодох юм” гэж нэгэн ухаантан өгүүлжээ. Тэгвэл хотол хорвоогийн оюуны соёлын оройн чимэг болсон ном эрдэнийг үсэг бичгээр туурвидаг шүү дээ.

Санаагаа бичгээр илэрхийлж, хол газар үг хэлээ дамжуулах болсон нь хүн төрөлхтний оюун ухааны асар том ололт ажээ. Эрт цагт сонсогч этгээд өөр газар байгаа үед санаа бодлоо илэрхийлэх эрмэлзлэлийн анхных нь дээс зангидах, модонд хэрчлээс гаргах, сүг дүрс зурах тэргүүтэй болзмол тэмдэг байжээ. Монгол нутгаас элбэг олддог хадны янз бүрийн сүг зураг ч өвөг дээдсийн маань нэн эртний үеийн үсэг бичгийн эхлэл мөн. Аливаа юмны дүр зургаар бүхэл өгүүлбэрийг илэрхийлэх болж, улмаар зургийн бичиг, дүрс бичиг, утгын бичиг буй болжээ.

Утгын бичгийн хөгжлийн дараагийн шат нь үет бичиг юм. Ийнхүү үсэг бичиг боловсрон хөгжсөөр манай эриний өмнөх X зууны үед Газрын дундад тэнгисийн зүүн эргээр оршиж байсан Финикт анхлан авианы бичиг үүсчээ. Энэхүү анхны авианы бичиг өрнө зүг дэлгэрэн Грек, Латин цагаан толгойн үндэс болжээ. Дорно зүг дэлгэрсэн нь Арамей, Сири, Согдоор дамжин Уйгур, Монгол бичгийн цагаан толгойн үндэс болжээ. Монголчуудын эртний өвөг болох Хүннү, Сяньби, Муюн, Тоба, Жужан нар тусгай бичигтэй байсныг судлаачид баталж байна. Мөн Кидан нар X зууны үед их бага хоёр бичигтэй байсан гэдэг. Энэ тухай үл өгүүлэн, он цагийн шалгарлыг даван туулж монгол туургатны оюуны соёлын арвин өвийг бүтээж ирсэн монгол бичгийн үүслийн тухай өгүүлье.

Монгол бичгийн үүсэл гаралтай холбоо бүхий хоёр зүйлийн домог эдүгээ бидэнд уламжлан иржээ. Нэг нь XVIII зууны үед Равжамба Данзандагвын зохиосон “Зүрхэн толтын тайлбар огторгуйн маани” хэмээх хэлзүйн бичигт “...Тэр цагт Зая Бандид (Саж Бандид Гунгаажалцан) Монгол улсад аль үсгээр туслах болох хэмээн шөнө тугдам барьж эрт манагар бэлэглэхүйд нэгэн эхнэр хүн мөрөн дээрээ хэдрэгэ модыг тавьж ирээд мөргөвөөс, тэрхүү бэлгээр Монгол улсын үсгийг хэдрэгэний дүрсээр эр, эм, эрс гурваар, чанга хийгээд хөндий ба саармаг гурваар зохиосон болой” гэсэн домог юм. Энд өгүүлсэнчлэн, Саж Бандид Гунгаажалцан (1182-1251) монгол үсгийг анх зохиосон бус харин тэрбээр 1243 онд 61 насан дээрээ монгол бичгийн хэлний авиазүйн бүтээл буюу анхны зүрхэн толт зохиосон болох нь нэгэнт тодорхой болжээ.

Хоёр дахь нь “Юань улсын судар”-ын 124-р ботид байгаа Уйгур түшмэл Тататунгатай холбогдсон домог юм. Тэнд өгүүлэхдээ: “Чингис өрнөш дайлж, Найман улс эвдрэхүйд Тататунга тамгыг авч дайжаад баригдав. Чингис хаан ухавчлан асууруун: - Даяны иргэд нутаг цөм миний болсон бөгөөтөл чи бээр тамга өвөрлөн хааш эчмүй хэмээхэд тэрбээр: “Түшмэлийн тушаал болой. Үхтэл сахиж угийн эзэнд өгсү хэмээмүй. Ямар аймшиггүй өөрийг сэтгэх аж” хэмээжүхүй. Хаан зарлиг болж, “Шударга элбэрэлт хүн ажгуу” хэмээгээд тамгыг юунд хэрэглэхийг асууваас: Аму цалинг оруулах, гаргах, эрдэмтнийг өргөмжлөх, аливаа үйлд хэрэглэж итгэмж болгомуй хэмээсэнд хаан таалж шадар болгожухуй. Түүнээс

хойш засаг зарлага тэргүүтэнд тамга хэрэглэн үүсгэж мөн түүгээр захируулав. Хаан “Чи тус улсын бичгийг нэвтэрхий мэдмүй” гэхэд Тататунга сурснаа өчсөн нь зарлигт нийлэлцсэн тул даруй хөвгүүд, дүү нарт уйгур үсгээр улсын хэлийг тэмдэглэхийг сургагтун хэмээн захив” гэсэн байдаг.

Чингис хаан Найманыг 1204 онд эзэлж авсан нь үнэн. Харин энэ үед монголчууд бичиг үсэгтэй болсон хэрэг огт бус бөгөөд алдарт монголч эрдэмтэн Б.Я.Владимирцовын бичсэнчлэн, Чингис хаан өөрийн эзэнт улсын хэрэгцээнд “боловсорчихсон бэлэн бичгийн хэл”-ийг авч ашигласан ажээ. Өөрөөр хэлбэл, монголын зарим аймагт хэрэглэж байсан уйгуржин монгол бичгийг Чингис хаан эзэнт улсынхаа хүрээнд хэрэглэжээ. Оросын нэрт монголч эрдэмтэн Г.Д.Санжеев энэ тухай “Ямар ч гэсэн 1204 онд Чингис хаан Найманыг бут цохиж, Найманы Даян хааны тамгыг барьж байсан уйгурыг олзолж, түүний тусламжаар төрийнхөө бичигт уйгур үсэг дээр үндэслэсэн монгол бичиг үсгийг хэрэглэсэн бололтой гэсэн нэгэн домог байдаг. Гэвч хэргийн гол нь Чингис хаан төрийнхөө бичиг хэргийг Согдоор дамжиж, Арамейгаас ирсэн шинэ үсгээр явуулах тухай тушаал гаргасанд бус, харин Чингис хааны үед монголчууд ямар нэгэн хэмжээгээр бэлэн болоод байсан утга зохиолын хэлийг хэрэглэж эхэлсэнд оршино” гэжээ.

Монголчууд XIII зуунаас хол эрт уйгуржин монгол бичгийн хэлтэй байсан гол баримт бол эртний монгол бичгийн хэл нь XIII-XIV зууны монголын аман аялгуунаас ихээхэн ялгаатай байгаа явдал юм. XIII-XIV зууны монголын аман аялгууны онцлогийг, тухайн үеийн монгол дуудлагаар нь хятад, араб зэрэг үсгээр галиглан тэмдэглэсэн ном зохиол, толь бичиг тэргүүтнээс бид олж мэддэг билээ. Хэл гэдэг тийм цөөн жилийн дотор амархан өөрчлөгддөг зүйл биш бөгөөд алгуур аажим хувьсдаг учраас бичгийн хэл нь аман аялгуунаас ихээхэн зөрөөтэй байна гэдэг бол тэрхүү бичгийн хэл бичиг үсэг олон жилийн өмнө үүссэн гэж үзэх бүрэн үндэстэй юм.

Монголчууд XIII зууны үед боловсорсон утга зохиолын хэлтэй, бичиг хэрэг хөтлөх тогтсон уламжлалтай байсны нэг нотолгоо бол 1225 онд бичсэн Чингисийн чулууны бичиг юм. Уг бичээст мөр тэтгэж бичих ёс тун нарийн харагдаж байдаг.

Монголчуудын дунд “уйгуржин монгол бичиг”, “монгол бичиг”, “худам монгол үсэг” анх хэдийд, хаанаас авсан тухай сүүлийн үед эрдэмтэн, судлаач нар өөр өөрийн бодол саналыг дурдан байна. Манай эрдэмтэн Ц.Шагдарсүрэн “Монголчууд XIII зуунд согд үсгийг уйгураас дам авч хэрэглэсэнгүй, харин VI-VII зууны үед Монгол, Уйгур хоёр одоогийн Тажикийн дээд өвөг Согд нараас нэгэн зэрэг бичиг үсэг авсан байж болох баримт гарч байна” хэмээн бичсэн буй. Мөн Өвөр Монголын эрдэмтэн Данзан “Монгол бичгийн үүслийн цагийн асуудал” шинжилгээний томоохон өгүүлэлдээ: “Эртний Монгол хэл аялгууны байдал, эртний монгол орон дахь бичгийн соёлын байдал, эртний монгол орны аймаг угсаатны соёлын харилцааны байдал ба хуучин монгол бичиг дэх хэлний болон үсэгзүйн онцлог зэргийг ерөнхийд нь шинжилж үзвэл, монголчууд XIII зуунаас хол эрт согд гаралтай уйгураас үсгийг авч хэрэглэсэн бөгөөд бодитой цагийн талаар 805-840 оны хооронд буюу эсвэл 971-1125 оны хооронд гэх хоёр цаг үед хэрэглэж эхэлсэн боломж нь өөр үеэс илүү байна” гээд, түүнийгээ олон баримтаар батлахыг хичээсэн байна. Монгол бичгийн хэл чухам хэдий үеийн ямар аялгууг тусгасан бэ? гэдэг асуулт юуны өмнө уг бичгийг авсан он цагтай холбогдох нь тодорхой бөгөөд энэ талаар ч судлаачдын санал нэг

мөр болж чадаагүй байна. Ямар боловч монголчууд согд гаралтай уйгуржин монгол бичгийг авч хэрэглэсэн нь 10 зуунаас наашгүй гэж үзэх үндэстэй юм. Тийм ч учраас бид монгол бичгээ мянган жилийн түүхтэй хэмээн ярьж буй.

1616-1911 оны хооронд оршин тогтнож ирсэн Дай Чин (Их Чин) улсын албан ёсны хэл болох манж бичиг нь монгол бичгээс үүссэнийг дурдах нь зүйтэй. Манжийн төрийг үндэслэн байгуулагч Нурхач хааны зарлигаар Эрдэнэ багш, Гагай заргач хэмээх хоёр хүн 1599 онд монгол бичгийг манж хэлэнд тааруулан, дусал бинт нэмэх зэргээр өөрчлөн зохиосон билээ. Эрдэмтэн судлаач нар манж бичгийг зохиосон энэ хоёр хүнийг монгол хүн байсан гэж үздэг.

Монгол бичиг боловсорч хөгжсөн нь

Монгол үсгийг анхлан боловсруулахдаа уйгур үсгийн 14 толгой нь монгол хэлний үг бүтээх авиалбарын тооноос арай цөөн тул хошоод, гурваад дүрсийг нийлүүлэн зарим үсгээ тэмдэглэсэн билээ. Тухайлбал ө, ү гэхэд аалеф, вав, йод гурвыг холбож бүтээжээ. Олон зуун жил монгол бичгээ сурч, сургаж ирэх явцад тэрхүү дүрс, зурлага бүрт тодорхой нэр цол өгсөн нь заах аргын өвөрмөц нэгэн зүйл юм. Титим, шүд, ацаг, өргөс, шилбэ, завж, гэдэс, сүүл, орхиц, нум, нуруу, эвэр, гээг, зартиг гэх мэтээр монгол бичгийнхээ дүрс, зурлага бүрийг ялган нэрлэсэн нь бичих хэрэглэлгүй нөхцөлд амаар хэлж өгөх боломжийг бүрдүүлжээ. Жишээ нь монгол гэсэн үгийг зурлагаар нь дуудан хэлж өгвөл, титим гээгтэй, залгаад гэдэс, их инхлэг, га-гийн хоёр шүд, өмнөө хоёр цэгтэй, дор нь гэдэс, төгсгөлд нь дэвсгэр “л” буюу эвэр гэх болно.

Нэн эрт цагт үсэг бичгээ боловсруулсан мэргэд маань олон нутгийн аялгууг нэн сайтар анхаарч, нутаг нутагт сэлгэн хэлдэг авиаг адил дүрсээр тэмдэглэсэн байдаг. Жишээ нь эрт одоогийн зарим аялгуунд үгийн эхэнд “ж” нь “я” болдог үзэгдлийг нарийн ажиглаж адил дүрсээр тэмдэглэсэн тул жасаг, ясаг, засаг гэж дуудах бүрэн бололцоотой байдаг. Үе үеийн олон мэргэд монгол бичгийг өөрчлөлгүй явж ирсний гол шалтгаан бол Төв Азийн өргөн уудам нутагт тархан суусан олон нутгийн аялгуутай монгол туургатныхаа алинд ч бэрхшээл төвөггүй ойлгогдох нарийн увидастай бичиг болохыг мэдэрч байсных буй заа. Өөрөөр хэлбэл монгол бичгийн авианзүйн тогтолцоонд монгол хэлний нутгийн олон аялгууны онцлогийг бахдууштай сайхан тусгаж чадсанд л хамаг учир байгаа билээ.

Монгол үсгийн бас нэгэн онцлогийг академич Ш.Лувсанвандан багш тайлахдаа, ”Хуучин монгол үсгийн нэг онцлог нь нэг үсэг үгийн эхэн, дунд, адагт янз бүрээр хувирдагт оршино. Ингэж нэг үсэг янз бүрээр хувирах нь эртний согд, уйгур бичигт ч нэгэн адил байсан юм. Нэг үсгийн янз бүрийн хэлбэртэй болсон нь үсгээр үг тэмдэглэхдээ уг үсгүүдийг бие биеэс нь салангад биш, залгаж бичихтэй холбогдон гарч ирсэн байна. Үг хэлэхэд хүний амнаас цувран гарах авиа бие биедээ нөлөөлж, мөн нэг авиа үгийн эхэн, дунд, адагт янз бүрээр хувирдагийн адил үсгийг цувруулан залгаж бичихэд мөн нэг үсгийн хэлбэр зэргэлдээ үсгийн бичлэгээс болж янз бүрийн хэлбэртэй болох нь зүйн хэрэг. Нэг авиа нөгөө зэрэгцээ авианыхаа нөлөөгөөр хувирдаг бол мөнхүү авиаг тэмдэглэсэн үсгийн хувилбарт зохих тусгалаа олж болох юм. Энэ учраас бид нэг авиаг тэмдэглэсэн үсгийн янз бүрийн хувилбарыг мөн нэг фонемын янз бүрийн хувилбартай харьцуулж үзэх бүрэн үндэстэй юм” гэсэн билээ.

Монгол бичиг он жилийн уртыг туулан боловсорч ирэхдээ эрт цагийн үгийн бүтцийг өчүүхэн ч алдагдуулалгүйгээр бидэнд авч ирсэн нь монгол хэлний хөгжил хувьсал бүхнийг

ташаагүй үнэн тэмдэглэсэн түүхэн сурвалж бичиг мэт ажээ. Орчин цагийн монгол хэлний дуудлагаас өөрөөр бичиж байгаа үг бүрийн цаана эх хэлний маань түүхэн хувьсал, үгийн гарлын учир шалтгаан, үндэсний хэл сэтгэхүйн маань бүхэл бүтэн түүх байгаа гэдгийг онцлон дурдах нь зүйтэй болов уу. Учир нь монгол бичгээ сурч судлахыг хичээх болсон өнөө үед, зарим шантарган, гэнэн хүн монгол бичгийг одоогийн аялгуунд тохируулан өөрчилж болдоггүй юм уу? гэж хэлэх нь хааяа тохиолдох юм. Энэ бол туйлын аминчхан үзлийн илрэл мэт бодогдож мэдэх үг ээ.

Монгол бичгээр бичдэг ёсыг зөрчиж, хэлэх аялгаа баримтлан бичнэ гэдэг эх хэлнийхээ эд эсийг зэрэмдэглэн тайрч хаяна гэсэн үг бөгөөд түүгээр хойч үеийнхнийхээ өмнө уучилшгүй нүгэлтэн болж мэднэ. Учир нь монгол хэл, монгол бичиг гэгч ганц өнөөгийн бидний өмч биш. Өнгөрсөн, одоо, ирээдүй цагийн түм буман монголчуудын өмч учраас нэгэн үеийн бид дур мэдэн бичиг үсгээ өөрчлөн засамжлан, хойч үеийнхнээ эх хэл-сэтгэхүйнх нь түүхээс холтгох эрхгүй.

Монгол бичиг бол монгол хэлний үгийн түүх гарлыг нягтлан тольдох толь бичиг юм. Наад захын үгээр жишээлэхэд хутга, хядах, чарга, чирэх гэх мэт үгийг монгол бичгээр ᠬᠤᠲᠤᠭ᠎ᠠ, ᠬᠢᠬᠠᠳᠤ, ᠴᠢᠷᠭ᠎ᠠ, ᠴᠢᠷᠢᠬᠡ гэгж бичнэ. Эхний хоёр үгийн язгуур нь хиду- бөгөөд хядаж хяргадаг юмны нэрийг хутга гэдэг болох нь илт харагдана. Нөгөө хоёр үгийн язгуур нь чир- бөгөөд чирч явдаг юмыг чарга гэдэг болох нь тодорхой байна.

Үсэгзүйн хувьд авч үзвэл XVI-XVII зууны үе хүртэлх бичгийн хэв маяг, үсгийн зурлага уугуул согд, уйгур үсэгтэй их төстэй байсан бөгөөд тийм ч учраас энэ үеийн монгол бичгийг уйгуржин монгол бичиг гэж нэрлэх нь бий. XVI-XVII зуунаас хойш сонгодог монгол бичгийн хэлний хэв маягийг олж, үсгийн зурлага, нэмэлт тэмдэг сэлт нь тогтворжин боловсорч, харь хэлний үгийг тэмдэглэх галиг үсгийн бүхэл бүтэн тогтолцоотой болж зөв бичих дүрэм ч жигдрэн цэгцэрсэн байна.

XVI-XVII зууны үед монголчуудын ном бичгийн үйлс нэн өрнөж, ном барлах, орчуулан туурвих үйл мандан дэлгэрч, сонгодог бичгийн хэл бүрэлдэн тогтжээ. Монгол бичгийн зөв бичих дүрэм жигдрэн цэгцрэхэд, XIII зуунаас эхлэн удаа дараа туурвиж ирсэн олон арван хэлзүйн бичиг, олон зүйлийн толь бичиг нэн чухал байв. Эдгээр “Зүрхэн толт” хэмээх хэлзүйн бүтээл цагаан толгой, үсгийн дүрмийг хамарсан төдийгүй хэл шинжлэл буюу дуун ухааны олон талыг багтааж байжээ. Нэгэн жишээ татахад, XIII зууны эцэс XIV зууны үед бүтээн туурвиж байсан Чойжи-Одсэр монгол бичгийн хэлзүйн бүтээл “Зүрхэн толт”-доо монгол хэлний авиазүй, хэлзүйн онцлогийг сайн тусгаж, үгийн эцэст үе битүүлэн орж чадах гийгүүлэгч үсгийг бүртгэн тогтоож 11 дэвсгэр үсэг гэж нэрлэжээ. Эртний монгол хэлний 11 дэвсгэр гийгүүлэгчээс 9 нь орчин цагийн монгол хэлэнд нэгэн адил дэвсгэрлэн орж байгаагаас үзэхэд тэр эрт цагт монгол хэлний гийгүүлэгч авиалбарын байрлалын чухал хуулийг нээсэн ажээ.

XIII зуунаас эхлэн Саж Бандид Гунгаажалцан, Чойжи-Одсэр, Рабжамба Данзандагва, Алшаа Дандар Лхаарамба, О.Жамьян, С.Шагж тэргүүтэн олон мэргэд, олон арван цагаан толгой, “Зүрхэн толт” хэмээх хэлзүйн дүрмийг боловсруулсаар иржээ. XX зууны эхэн үед С.Шагж багшийн “Үсгийн дүрмийн толь” гарч, өдгөө хүртэл Өвөр Монгол, БНМАУ, Буриад бүгд л зөв бичихзүйн хувьд мөрдлөг болгож байгаа билээ.

Монгол хэл ба монгол бичиг

Хүн төрөлхтний хэл гэж юу вэ? гэдэг тухайд олон янзын тодорхойлолт байдаг боловч хамгийн түгээмэл нь “Хэл бол харилцааны хэрэглүүр”, “Хэл бол сэтгэхүйн зэвсэг” болно.

Ийн үзвэл, Монгол хэл маань монгол угсаатны харилцахуйн хэрэглүүр, сэтгэхүйн зэвсэг нь юм.

Монгол хэл нь гарлын хувьд алтай язгуурын хэл буюу түрэг, манж-түнгүс, солонгос, япон хэлтэй холын хамаатан бөгөөд хэв шинжийн хувьд залгамал (agglutinative) болно. Өөрөөр хэлбэл, үг бүтэх ёсны тухайд үгийн цөм утгыг хадгалсан язгуурын араас үг бүтээх, үг хувилгах бүтээврүүд угсран ордог. Тэгвэл ийм онцлогтой хэлэнд зөв бичихзүйн ямар зарчим тохирох вэ? гэдэг асуулт урган гарна. Бидний өвөг дээдэс 1000 шахам жилийн тэртээ эх хэлнийхээ мөн чанарыг сайтар ухаарч, үгзүйн зарчимд тулгуурласан зөв бичихзүйтэй монгол бичгийн хэлийг боловсруулан хэрэглэсээр иржээ. Харин шинэ үсгийн зөв бичих дүрэм энэ уламжлалаас хазайсныг хэлний мэргэжилтэн хэн бүхэн мэдэх билээ.

Монгол хэл, монгол бичиг хоёрын шүтэлцээг ярихын өмнө “бичгийн хэл”-ний тухай товч дурдах ёстой. Аливаа улс гүрэн хэл, соёлоо эрхэмлэн дээдэлж, харь хэлний нөлөө, хар ярианы хэлний тусгал зэргээс сэрэмжлэхдээ юун түрүүнд бичгийн хэлээ цэвэр ариун байлгах тухайд анхаарч, төрийн бодлого нь ч үүнд чиглэдэг. Бичгийн хэл гэдэг нь зөв бичихзүй, зөв дуудахзүй, хэлзүй, найруулгазүйн тогтсон хэм хэмжээтэй сайтар боловсорсон хэл юм. Бас аман бичгийн хэл гэж бий. Бичгийн хэлийг даган мөрдөх, түүний дархлааг бэхжүүлэхэд төр засгийн оролцоо нэн чухал.

Аливаа хэлний тухайд, хэр зэрэг эртний хэл вэ?, тухайн үндэстэн угсаатан хэдийд бичиг үсэгтэй болсон бэ?, тэр бичиг үсгээр хэдий хэмжээний өв соёл уламжилсан бэ?, хэдийд ном барлаж эхэлсэн бэ?, хэдий үед бичгийн хэл нь бүрэн цэгцэрсэн бэ? гэх зэрэг асуудал зүй ёсоор тавигддаг.

Оросын алдарт монголч эрдэмтэн Б. Я. Владимирцовын анхлан үечилж тогтоосноор, монгол бичгийн хэл нь эртний, дундад, орчин цагийн хэмээсэн үе шатыг туулж иржээ. Манай эрдэмтэн академич Д. Төмөртоогоо багш бээр монгол бичгийн хэлний хөгжлийн үечлэлийг сонгодог бичгийн хэлний өмнөх болон сонгодог бичгийн хэлний гэсэн хоёр үе болгох нь зүйтэй хэмээгээд учир шалтгаан, үндэслэлийг тодорхой бичсэн байдаг. XVII зууны эцэс гэхэд монгол бичгийн хэл маань зөв бичих дүрэм, хэл найруулгын хувьд хэдийнээ хэвшин тогтсон, харь үгийг тэмдэглэх тогтолцоот галиг үсэгтэй, орчуулгын нарийн чанд зарчимтай сонгодог бичгийн хэл болсныг зөвхөн бид бус, дэлхийн алдартай монголч эрдэмтэд судлан тогтоосон билээ.

Аливаа улс үндэстэн өөрийн бичгийн хэлний өв уламжлалыг хойч үедээ эзэмшүүлэхийг эрхэмлэн чухалчилж, үе үеийн бичгийн мэргэдийн зохиол бүтээлийг өвлүүлэн үлдээдэг нь тэр хэл оршин тогтохын нэг үндэс болдог. Академич Ш. Лувсанвандан багштан “Монгол бичгийн хэл” хэмээх өгүүлэлдээ “Бичгийнхээ хэлийг сайн эзэмших нь мянган жилийн өмнө бичсэн хүний зохиолыг уншиж, өөрийн бичсэн зохиолыг мянган жилийн дараа ч хүнд уншуулах боломжтой болно” гэж бичсэн байдаг. Лу багшийнхаа “Бичгийнхээ хэлийг сайн эзэмших нь...” хэмээснийг онцлон санах нь зүйтэй буй за.

Өдгөөгөөс 800 жилийн тэртээ Их эзэн богд Чингис хаантан бээр монгол бичгийг төрт улсын хэмжээнд албан ёсоор хэрэглэж, “Мөнх тэнгэрийн хүчинд Их монгол улсын далай хааны зарлиг эл (өөрийн харьяат) булха (харийн) иргэнд (хүн ард, улс оронд) хүрвээс биширтүгэй, аюутугай” хэмээсэн зарлигт хасбуу тамга дарж, “Их засаг” хэмээх алдарт цааз хуулиа улсын заргач Шихихутугаар найруулан бичүүлж, хянан журамлаж, цагаан цаасан

дээр монгол бичгээр сийрүүлж, хөх дэвтэрт дэвтэрлүүлж “ургийн урагт бүү егүүтгэтүгэй” хэмээн зарлигласан бүлгээ.

Эзэн богд Чингис хаантан үсэг бичиг, ном судар, бичгийн мэргэдэд нэн хүндэтгэлтэй хандаж, тэдгээрийн үнэ цэнийг гүн гүнзгий ухаарсан хүмүүн байсныг түүх сударт олонтоо тэмдэглэжээ. Тийм учраас, үр хүүхэд, дүү нар, өрлөг жанждаа монгол бичигт сургаж, төрийн аливаа үйл хэргийг монгол бичгээр хөтлөн явуулж байсан баримт олон бий.

Тухайлбал, өрнө зүгт оршин тогтож байсан Ил хааны улс, Алтан ордны улс, Цагаадайн улсын хожуу үеийн хаад ч гэсэн дипломат харилцааны албан бичигт монгол бичгээ тогтвортой хэрэглэж байжээ. Үүний нэг жишээ нь, 1305 онд Ил хаан Өлзийтөөс Францын Гоо Филиппт явуулсан албан захидал юм. Дэлхий дахины энх амгаланг эрхэмлэсэн “*ünen kü joqilduqui-ača sayin yaγun aqū*” [Үнэнхүү зохилдохоос (найрамдахаас Ш. Ч.) сайн юун аху (байх)] хэмээх алдарт үгтэй энэ албан захидлыг Эзэн Чингисийн үеэс тогтоосон засаг зарлигийг чанга баримталсны гэрч хэмээн үзвэл зохино.

Бас нэгэн сонин баримтыг дурдвал, Египетийн Мамлюк (1250-1517) улсын хаад Алтан ордны улсын хаадтай харилцсан албан захидлаа их төлөв монгол хэл, монгол бичгээр явуулж байжээ. Энэ нь дундад зууны үед Монголчуудын нөлөө хүч нэн их байсныг харуулахын хамт, бичгийн соёл, тогтсон уламжлал нарийн чанд байсны илрэл юм.

Чингис хаантан 1221 онд Гуулин улсын ванд зарлиг илгээж, бэх, бийр, янтай, цаас арван түмэн хуудас явуул хэмээсэн мэдээ “Гуулин улсын судар”-ын хорин хоёрдугаар дэвтэрт байдаг байна.

Энэ мэт баримтаар хашин үзвэл, Чингис хаан – бичиг үсэг – ном дэвтэр – бичгийн хүн хэмээх хэлхээ холбоо нь XIII зууны үед, Эзэн богд Чингис хааны суу билгээр бүрэлджээ хэмээн үзэж болох буй за.

Хүн төрөлхтний бичгийн соёлыг “гадаад далай” хэмээн зүйрлэвээс түүний нэгэн тасаршгүй цутгал нь монгол бичиг, түүгээр туурвисан судар шастир мөнөөс мөн. XIII зууны Монголын олон аймгуудын бичиг соёлын гол горхийг “Их монгол улсын бичиг” хэмээх голдиролд оруулан, гадаад далайд цутгах их мөрөн болгохын эх үндсийг тавьсан гавьяатан болбоос Эзэн богд Чингис хаантан юм. Чухамдаа Төв азийн өргөн уудам нутагт тархан суусан монгол угсаатныг ном соёлоор холбох “алтан аргамж” нь “монгол бичиг” мөн болой.

1928 онд Халимагт бичиг үсгээ солих бодлогыг хэрэгжүүлэх зорилготой эрдэм шинжилгээний хурал болжээ. Тэр хуралд академич Б. Я. Владимирцов оролцож “Монгол болон Ойрд овог аймгуудын утга зохиол ба хэлний эдүгээгийн байдал” гэсэн илтгэл тавьсан нь уг хурлын үзэл санаанд харшилсан тул олон жил архивт дарагдаж байжээ. Үүнийг Японы залуу эрдэмтэн Араи Юкиясү 2004 онд олж, хуулбарыг хэвлүүлсэн юм. Энэ илтгэлд “Соёлын амьдралын чухал гол зэвсэг нь хэл ба бичиг үсэг байдаг учир монголчуудын хэл ба бичиг үсэг эдүгээ ямархуу байдалд байгаа вэ гэдэг асуудал гарч ирнэ. Эдүгээ ихэнх Монгол аймгууд өөрөөр хэлбэл тусгаар Монгол улсын нутаг дэвсгэр дээр оршин сууж, энэ тусгаар улсад багтаж буй бараг бүх ард түмэн түүнчлэн урд зүгийн нийт монголчууд (барагцаалбал 3.000.000 монгол), манай буриадууд, мөн Төвөд болон Туркестанд аж төрж байгаа монгол угсааны овог аймгуудад бүгдэд нь байдаг нийтлэг нэг зүйл бол тэд өөрсдийн гэсэн бичиг үсэг, монгол бичгийн хэлтэй байдагт оршино. Энэхүү хэл бичиг нь маш эрт цагт үүсэж хэвшсэн бөгөөд юутай ч Чингис хаанаас өмнөх үед хамаатай төдийгүй одоо хэр нь хадгалагдсаар, хэрэглэгдсээр, улам боловсронгуй болсоор байна. Тиймээс энэ бол монголчуудын соёл, боловсролын хамгийн чухал нандин өв сан юм. . . Энэ бичиг үсэг урт удаан он жилийн туршид

оршин тогтносон олон төрөл зүйлийн уран зохиол бичигдсэн байдгийн ач үрээр тун нарийн боловсронгуй хэл болон хөгжсөн байх юм. Монголчуудын хувьд үнэ цэнэтэй болгож байдаг нэг онцлог шинж чанарыг монгол бичгийн хэл өөртөө хадгалж байдаг. Энэ нь монгол үсэг бичиг тэдний хувьд нийт дундын байдагт оршино. Буриад хүний бичсэнийг Бээжин хотын гудамжид яваа монгол, Ховд аймгийн дөрвөд угсааны хүний бичсэнийг Төвөд орны уулын дэвсгээр амьдрах монгол хүн тус тус төвөггүй уншиж ойлгож чадна. Энэ бол нэгдмэл нийтийн өв сан” хэмээн бичээд өөр өөр улс гүрний бүрэлдэхүүнд багтдаг арабуудыг бичиг үсэг нь зангидаж байдгийг жишээ болгожээ.

Тэр үед академич Б. Я. Владимирцов бээр хожим монголчууд бичиг үсгээ халж солихыг яахин төсөөлөх билээ.

Монгол бичгээрх оюуны өв сан

Монгол туургатан олон зууны турш үндэснийхээ бичгээр оюуны соёлын хосгүй арвин өв сан бүтээжээ. Цаг цагийн гамшиг, үе үеийн үрэгдлийг тэсэж өнгөрөөсөн нь л бидэнд хүрч иржээ гэж бодоход өдгөө Монгол оронд болон дэлхийн олон орны номын санд хадгалагдаж байгаа монгол номыг мэдсэн дуулсны хэрээр хэмжээлэн санахад өөрийн эрхгүй бахдан бишрэх сэтгэл төрөх ажээ.

Зөвхөн улсын нийтийн номын санд монгол бичгээр туурвисан 20000 орчим судар шастир хадгалагдаж байна. Мөн ОХУ, БНХАУ, АНУ, Англи, Япон, Герман, Швед, Польш, Унгар, Франц зэрэг дэлхийн олон орны номын санд монгол бичгээр туурвисан судар шастир үлэмж тоотой байдаг бөгөөд Б.Я.Владимирцов, П.Аалто, Л.С.Пучковский, В.Хайссиг, Н.Поппе, Ж.Крюгер, Ч.Бауден, Л.Бэшэ, А.Г.Сазыкин, В.Л.Успенский нар тэдгээрийн гарчгийг хэвлэн нийтлүүлсэн нь хэд хэдэн боть ном болсон байдаг.

Ийнхүү монгол бичиг монгол угсаатны олон зуун жилийн судар шастирыг улируулан тээхийн зэрэгцээ бусад улс үндэстний уран зохиолын дурсгалтай танилцуулах гүүр болж байсан бодит баримт аль тэртээ XIII зууны үед холбогддог. Мөн өрнө дорны олон хэлнээс орчуулсан орчуулгын арвин сан хөмрөг энэ л бичгээр уламжлан үлджээ.

Монгол туургатны дотроос ухаан билгээрээ тодрон гарсан олон мэргэд зүйл зүйлийн ухааны нэн арвин шастир судар туурвисан байхаас гадна эртний дорно дахины соёлт орнуудын шилдэг зохиолын орчуулгын баялаг сан хөмрөгийг бий болгожээ. Ганцхан жишээ дурдахад, монголын их хаадын намтар, хатад, хөвгүүд, гавьяатан сайд, түшмэдийн шастир болон Юань улсын үеийн монголын эдийн засаг, соёлын түүхийг өргөн хамарч бичсэн “Юань улсын судар” хэмээх 210 дэвтэр номыг монголын нэрт бичгийн хүн, хятадач Дандаа (чухам нэр нь Дэмчигдорж) 1917-1928 хооронд орчуулсан нь гар бичмэлээр улсын нийтийн номын санд хадгалагдаж байна. Мөн энэхүү “Юань улсын судар”-ын 14-р дэвтэр манж хураангуйг орчуулсан нь бас байх юм. Ганжуур, Данжуур тэргүүтэй өдий төдий судар шастирыг төвөд хэлнээс орчуулсныг хэн бүхэн мэдэж байгаа. Монгол бичгээр байгаа орчуулгын сан хөмрөгт 1921-1945 он хүртэл өрнө дахины хэлнээс орчуулсан бас нэлээд арвин ном зохиол бий билээ.

Монгол бичгээр уламжилсан судар шастир, намтар түүх, данс хараа, албан бичиг тэргүүтэн нь монгол туургатны туулж ирсэн зам мөр, туурвиж бүтээсэн оюун ухаан, мандаж буурсан баримт түүхийг танин мэдэх гол түлхүүр бөгөөд монгол хүний сэтгэлгээний онцлог, монгол хэлний авианы тогтолцоо, үгийн бүтэц хэлбэржилт, үгийн сан, үгийн гарал түүх, өгүүлбэрийн бүтэц зохион байгуулалт, найруулгын ур маягийг гагцхүү монгол бичгийнхээ сан хөмрөгөөс л тодруулах боломжтой юм.

Монгол бичгээ сурч судлахын учир

1. Монгол бичиг бол үсгийн хэв, тиг зурлага, үсэг холбох ёс, бичих чиглэл зэргээрээ өвөрмөц сонин. Ийм бичиг үсэгтэй өөр улс үгүй. Өөрөөр хэлбэл, монгол бичиг бол дэлхийн бичиг соёлт бусад улс үндэстнээс монгол угсаатныг ялгах нут гэрч юм.
2. Монгол бичиг нь хөгжлийнхөө явцад бичих ур маяг, тиг зурлагын олон зүйл хэлбэрийг буй болгосон бөгөөд хурдан бичиж тэмдэглэх өргөн боломжийг өөртөө шингээсэн байдаг.
3. Орчин цагийн монгол хэлний дуудлага адил, утга өөр үгс болон адил дуудагдах хэлзүйн хэлбэрийг ялган бичих боломжтой. Харин шинэ үсэгт ийм боломж үгүй бөгөөд дуудлага дагуулан бичих тул бодох сэтгэх шаардлага гардаггүй. Наад захын жишээ авахад, сурагчид гэвэл монгол бичгээр бичихдээ сурагч хүнд үү, олон сурагч уу гэдгийг эрхбиш бодох ёстой. Энэ бүхэн хүүхдийг багаас нь бичиг үсгийн үйл хэрэгт нягт нямбай ханддаг, хам сэдвээс нь утгыг ялгаж мэдэх бүтээлч чадамжийг олгоно.
4. Өөрийн удам угсаа, язгуур үндсээ үл хайхрахаа больж, өвөг дээдсийнхээ оюуны их соёлоор бахархах сэтгэлтэй болно.
5. Монгол бичгийн хэлний зөв бичих дүрэм нь үгийн язгуур, залгавар бүтээврийн хэлбэрийг эвддэггүй, залгамал хэлний онцлогийг бүрэн тусгасан тул монгол үгийн бүтцийг тогтвортой хадгалж ирсэн. Олон зуун жил зөв бичих дүрэм нь тогтвортой байж, улам боловсронгуй болсон тул монгол үгийн уугуул бүтэц, гарал хувьслыг тов тодорхой мэдэх боломж олгодог. Энэ онцлог нь үгийг задлах, хувилгах, хөрвүүлэх, орчуулах зэрэг програм хангамж зохиоход тун тохиромжтой. Өөрөөр хэлбэл, зөв бичихзүй нь монгол хэлний зүй тогтлыг нарийн чанд тусгасан гэсэн үг.
6. Хамгийн гол зүйл нь үе үеийн бичгийн хүмүүсийн зохиол бүтээлийг уншиж, сонгодог монгол бичгийн хэлний найруулга, ур маягийг эзэмших бололцоо олгодог. Энд нэг зүйлийг тэмдэглэн хэлэхэд, монгол бичгээр анх туурвисан зохиол бүтээлийг шинэ үсгээр хөрвүүлэхэд шүлэг найргийн үе бадаг, холбоц, хэмнэл зэрэг нь алдагдаж, найруулгын тэгш хэм, өнгө аяс нь өөрчлөгддөг.
7. 1940-өөд онд бичиг үсгээ сольж, шинэ бичиг үсгээрээ өмнөх олон зууны судар шастирыг хөрвүүлж олны хүртээл болгоогүйн улмаас бичгийн хэлний үг хэллэг, утга найруулгыг үл ойлгогчид өнөө цагт олширчээ. Гэвч ахмад болон залуу үеийн залгамж холбоо тасарчихаагүй байгаа дээр монгол бичгээ сурах нөхцөл боломж бүрэн байна.
8. Монгол бичгийн олон улсын кодыг 2000 онд батлуулж, олон улсын оюуны өмчид бүртгүүлсэн. Үүний үр дүнд монгол бичгийг цахим хэрэгслээр боловсруулах, цахим сүлжээгээр дэлхийн аль ч оронд илгээх боломжтой боллоо. Өөрөөр хэлбэл, компьютер, монгол бичиг хоёр ойр дотно нөхөрлөх болсон тул өнөөгийн залуучууд цахимаар бичих, харьцах боломж бүрдсэн гэсэн үг.

Энэ мэтийг ярьвал тун ч их зүйл бий. Багцлан хэлбэл, 800 шахам жил тасралтгүй хэрэглэж ирсэн монгол бичгээ сурч, түүгээр туурвисан зохиол бүтээлийг судлахаас өөр гарц үгүй юм.

Дүгнэн хэлбэл, монгол бичиг нь хамаг монгол туургатны хэл аялгууг хамтатган тэмдэглэж, хэдэн зуун жилийн түүхийн түүчээ, судар шастирын цоморлигийг улираан уламжлуулсан монголчууд бидний эх хэл, эв нэгдэл, эрдэм мэдлэг, тусгаар тогтнол, төрт ёсны эрхэм нандин гэрч, хүн төрөлхтний оюуны соёлын гайхамшигт өв мөн болно.

МУИС-ийн багш доктор (Sc.D), профессор Ш.Чоймаа

ТОЛЬ АШИГЛАХ ЗААВАР

1. Толгой үг

1.1. Кирил үсгээр

- Тус толь бичгийн толгой үгийг тод хараар бичиж, ард нь монгол бичгээр хадсан бөгөөд товч тайлбарыг хаалтад оруулсан болно.
зорчигч ᠵᠣᠷᠴᠢᠨ (зорчин явагч, жуулчлагч)
- Толь бичигт үйл үгийг толгойлохдоо үйлт нэрийн “-х”-ээр хувилгаж, үйл үндсийг « | » тэмдгээр зааж өгөв.
дэмж|их ᠳᠡᠮᠵᠢᠬᠢ (дэм үзүүлэх, туслах, тэтгэх)

1.1. Монгол үсгээр

- Орчин цагийн монгол хэлэнд бичлэг, дуудлага ижил боловч, эртний монгол хэлэнд дуудлага, бичлэг, утга нь өөр өөр үгс буй. Тэдгээрийг дүрс ялган бичих үгс ч гэдэг. Эдгээр үгсийг ром тоогоор дугаарлан, улаанаар бичив.
горхи I ᠭᠣᠷᠬᠢ (гол ~, ~ булаг)
II ᠬᠣᠷᠬᠢ (хэл бүхий гархи, бүсний ~)
- Монгол бичгийн уламжлалт бичлэгтэй үгсийг улаанаар онцлон бичив.
оюу ᠣᠶᠤ (эрдэнийн чулуу)
гэнэт ᠭᠡᠨᠡᠲᠦ (огцом, санамсаргүй)
- Орчин цагийн монгол хэлний дуудлагад ойртуулан бичдэг болсон боловч бичгийн хэлнээ түгээмэл тохиолддог хэлбэрийг хаалтанд оруулан толгойлов.
цаад ᠴᠠᠭᠠᠳᠠ (наад ~, ~ тал)

2. Толгой үгийн тайлбар

2.1. Үгийн утгыг тайлбарлахдаа дугаарлан эхэнд нь үндсэн буюу шууд утгыг, дараа нь салаа болон шилжсэн утгыг араб тоогоор дугаарлан орууллаа.

идээ ᠢᠳᠡᠭᠡ (① ~ ундаа, цагаан ~ ② арьс шир боловсруулах уусмал ③ цайны ~ ④ ~ бээр)

2.2. Холбоо болон хоршоо үгээр тайлбарлахдаа тухайн толгой үгийг орлуулан хэрэглэх « ~ » тэмдэгт ашиглав.

ажил ᠠᠵᠢᠯ (~ үйлс, ~ хөдөлмөр)

3. Үгийн хувилал

3.1. Нэр үгийн хувилал

- Түгээмэл хэрэглэгддэг жинхэнэ нэр үгсийг тийн ялгал, хамаатуулах, олон тооны нөхцөлөөр хувилгав.
байшин *байшин* (~ *барилга*) /~гийн/ *байшин* *бай* /~д/ *байшин* *бай* /~г/ *байшин* *бай* /~аас/ *байшин* *бай* /~аар/ *байшин* *бай* /~тай/ *байшин* *бай* /~руу/ *байшин* *бай* /~аа/ *байшин* *бай* *о.тоо* /~ууд/ *байшин* *бай*
- Харьяалах, өгөх орших, гарахын тийн ялгалын нөхцөлөөр хувилсан жинхэнэ нэрийн тогтворгүй “н”-ийг улаанаар тодрууллаа.
нүд *нүд* (*харах эрхтэн*) /~ий/ *нүд* *нүд* /~д/ *нүд* *нүд* /~ийг/ *нүд* *нүд* /~ээс/ *нүд* *нүд* /~ээр/ *нүд* *нүд* /~тэй/ *нүд* *нүд* /~рүү/ *нүд* *нүд* /~ээ/ *нүд* *нүд* *о.тоо* /~үүд/ *нүд* *нүд*
- Толгой үг нь олон тооны нөхцөлөөр хувилдаг тохиолдолд *о.тоо* гэж бичээд араас нь хувиллыг оруулав.
муур *муур* (*мийн төрөл, муужгай*) /~ын/ *муур* *муур* /~т/ *муур* *муур* /~ыг/ *муур* *муур* /~аас/ *муур* *муур* /~аар/ *муур* *муур* /~тай/ *муур* *муур* /~луу/ *муур* *муур* /~аа/ *муур* *муур* *о.тоо* /~ууд/ *муур* *муур*
- Түгээмэл хэрэглэгддэг тэмдэг нэрийг -втор⁴, -втордуу², -дуу² гэсэн тэмдэг нэрийн зэрэг болон баймжит -хан⁴ бүтээврээр хувилгаж, тайлбарын араас орууллаа.
тэгш *тэгш* (~ *шулуун, эрх ~, ~ тоо*) /~дүү/ *тэгш* *тэгш* /~дүүхэн/ *тэгш* *тэгш* /~хэн/ *тэгш* *тэгш*
цөөн *цөөн* (*олон биш, ~ малтай*) /~вөр/ *цөөн* *цөөн* /~вөрдүү/ *цөөн* *цөөн* /~дүү/ *цөөн* *цөөн* /~дүүхэн/ *цөөн* *цөөн* /~хэн/ *цөөн* *цөөн*
- Үндсэн тооны нэрийг толгой үг болгон оруулаад дэс, хам, тойм, түгээл тоо үүсгэх дагавар болон баймжит –хан⁴ бүтээврээр хувилгаж, тайлбарын араас бичив.
тавь *тавь* (*тооны нэр*) /~аад/ *тавь* *тавь* /~н/ *тавь* *тавь* /~д/ *тавь* *тавь* /~дагч/ *тавь* *тавь* /~дахь/ *тавь* *тавь* /~дугаар/ *тавь* *тавь* /~т/ *тавь* *тавь* /~тай/ *тавь* *тавь* /~уул/ *тавь* *тавь* /~таа/ *тавь* *тавь* /~хан/ *тавь* *тавь*

3.2. Үйл үгийн хувилал

- Түгээмэл хэрэглэгддэг үйл үгийг хэв /**хэв**/, байдал /**бай**/, нөхцөлдүүлэн холбох /**нөх.х**/, тодотгон холбох /**тол.х**/, биеэр төгсгөх /**бие.т**/, цагаар төгсгөх /**цаг.т**/ -ийн нөхцөлөөр хувилгасан болно.
яв|ах *яв|ах* (① *одох, зорчих* ② *алхах*)
хэв /~уул/ *хэв* /~гд/ *хэв* /~лд/ *хэв*
бай /~чих/ *бай* /~цгаа/ *бай* /~схий/ *бай*
нөх.х /~ж/ *нөх.х* /~аад/ *нөх.х* /~н/ *нөх.х* /~саар/ *нөх.х* /~вч/ *нөх.х* /~бал/ *нөх.х* /~баас/ *нөх.х* /~магц/ *нөх.х* /~тал/ *нөх.х* /~хлаар/ *нөх.х* /~нгуут/ *нөх.х* /~нгаа/ *нөх.х*

Тод.х /~сан/ **Тод.х** /~аа(гүй)/ **Тод.х** /~даг/ **Тод.х** /~х/ **Тод.х** /~маар/ **Тод.х** /~хуйц/
Тод.х /~лгүй/ **Тод.х** /~лтай/ **Тод.х** /~ууштай/ **Тод.х** /~шгүй/ **Тод.х**
бие.т /~я/ **Тод.х** /~гтун/ **Тод.х** /~г/ **Тод.х** /~аарай/ **Тод.х** /~аасай/ **Тод.х** /~аач/
Тод.х /~уузай/ **Тод.х** /~сугай/ **Тод.х** /~тугай/ **Тод.х**
цаг.т /~в/ **Тод.х** /~жээ/ **Тод.х** /~лаа/ **Тод.х** /~на/ **Тод.х**

- Үйл үгийг хувилгахад эгшиг болон үе жийрэглэснийг нь онцлон улаан болгов.

нис|эх **Тод.х** (*агаарт хөөрөх, халих*)

хэв /~гэ/ **Тод.х** /~лд/ **Тод.х**

бай /~чих/ **Тод.х** /~цгээ/ **Тод.х** /~схий/ **Тод.х**

нөх.х /~ж/ **Тод.х** /~ээд/ **Тод.х** /~н/ **Тод.х** /~сээр/ **Тод.х** /~вч/ **Тод.х** /~вэл/ **Тод.х**
/~вээс/ **Тод.х** /~мэгц/ **Тод.х** /~тэл/ **Тод.х** /~хлээр/ **Тод.х** /~нгүүт/ **Тод.х** /~нгээ/
Тод.х

Тод.х /~сэн/ **Тод.х** /~ээ(гүй)/ **Тод.х** /~дэг/ **Тод.х** /~х/ **Тод.х** /~мээр/ **Тод.х** /~хүйц/
Тод.х /~лгүй/ **Тод.х** /~лтэй/ **Тод.х** /~үүштэй/ **Тод.х** /~шгүй/ **Тод.х**

бие.т /~е/ **Тод.х** /~г/ **Тод.х** /~ээрэй/ **Тод.х** /~ээсэй/ **Тод.х** /~ээч/ **Тод.х** /~үүзэй/
Тод.х

цаг.т /~в/ **Тод.х** /~жээ/ **Тод.х** /~лээ/ **Тод.х** /~нэ/ **Тод.х**

жив|эх **Тод.х** (*хөвөхгүй доош орох, усанд ~*)

хэв /~үүл/ **Тод.х**

бай /~чих/ **Тод.х** /~знэ/ **Тод.х** /~цгээ/ **Тод.х** /~схий/ **Тод.х**

нөх.х /~ж/ **Тод.х** /~ээд/ **Тод.х** /~н/ **Тод.х** /~сээр/ **Тод.х** /~вч/ **Тод.х** /~вэл/
Тод.х /~вээс/ **Тод.х** /~мэгц/ **Тод.х** /~тэл/ **Тод.х** /~хлээр/ **Тод.х** /~нгүүт/
Тод.х /~нгээ/ **Тод.х**

Тод.х /~сэн/ **Тод.х** /~ээ(гүй)/ **Тод.х** /~дэг/ **Тод.х** /~х/ **Тод.х** /~мээр/ **Тод.х** /~хүйц/
Тод.х /~лгүй/ **Тод.х** /~лтэй/ **Тод.х** /~үүштэй/ **Тод.х** /~шгүй/ **Тод.х**

бие.т /~е/ **Тод.х** /~гтүн/ **Тод.х** /~г/ **Тод.х** /~ээрэй/ **Тод.х** /~ээсэй/ **Тод.х** /~ээч/
Тод.х /~үүзэй/ **Тод.х**

цаг.т /~в/ **Тод.х** /~жээ/ **Тод.х** /~лээ/ **Тод.х** /~нэ/ **Тод.х**

МОНГОЛ БИЧГИЙН ЗӨВ БИЧИХЗҮЙ

❖ Монгол бичгийн зөв бичих зарчим

Хүн төрөлхтөн түүхийнхээ хугацаанд зургийн бичиг, дүрс бичиг, утгын бичиг, үет бичиг, авианы бичгийг бий болгон хэрэглэж ирсэн бөгөөд хамгийн боловсронгуй нь авианы бичиг юм. Монгол бичиг бол монгол хэлний эгшиг, гийгүүлэгч авиа (*авиалбар*)-г тов тодорхой ялган тэмдэглэдэг нэгэн төрлийн авианы бичиг билээ. Авианы бичигтэй аль ч хэлний зөв бичихзүй нь **а/ авианзүй, б/ үгзүй, в/ түүхэн уламжлал** хэмээх гурван зарчимд үндэслэдэг.

1. Аман ярианы тухайн үеийн онцлогийг баримтлах буюу авианы түүхэн хувьслын орчин үеийн байдал, дуудлагыг тусгаж бичих нь авианзүйн зарчим юм. Авианзүйн зарчим нь хэлэх аялгыг дагуулан, авиачилж бичихийг хэлэх бөгөөд ярианы хэл, бичгийн хэлний дуудлагыг ойр байлгахыг эрхэмлэдэг. Монгол бичиг бол нэг зүйл авианы бичиг болохын хувьд хэлэх аялгатайгаа адил буюу ойр бичих үгс мэдээж үлэмж арвин буй. Жишээ нь: «*ном*», *дэвтэр*, *морь*, *хонь*, *ав-*, *өг-*, *сайн*, *сайхан*...» гэх мэт өдий төдий үгийг жагсаан бичиж болно.
2. Үгзүйн зарчим гэдэг нь үгийн бүтцийг тогтвортой хадгалахыг эрхэмлэж, үгийн язгуур үндэс, түүнд угсран залгах дагавар, нөхцөлийн хэлбэр бүтцийг амьд ярианы хэлний дуудлагад тохируулан эвдэхгүй байлгахыг чухалчилдаг. Эртний уламжлал бүхий авианы бичигтэй дэлхийн олон хэлний ихэнх зөв бичихзүй ч энэ зарчимд үндэслэсэн билээ.

Монгол бичгийн зөв бичихзүй үгзүйн зарчимд үндэслэж үгийн бүтцийг эвдэлгүй бичдэг тул өнөөдөр бид монгол бичгээсээ монгол хэлний төрөл үгийн язгуур, үгийн гарал хувьсал, монгол хэлний үг бүтэх ёс, дагавар нөхцөлийн хэв байдлыг нэн тодорхой ажиглан харж чаддаг. Өөрөөр хэлбэл монгол бичигт үгийн язгуур үндэс, түүнд залгах залгаврын хэв байдал хувирдаггүй тогтвортой юм. Жишээ нь, кирил үсгийн дүрмээр “*дарах*” гэж бичдэг үгийг монгол бичгээр *даруху* – даруху гэж бичих бөгөөд энэ үйл үгийн *дару* – дару гэсэн язгуур нь уг үгтэй төрөл бүх үгэнд тогтвортой хадгалагдаж ирснийг доорх жишээнээс харж болно.

- даруху* – **дарах**
- дарулаху* – **дарлах**
- даругдаху* – **дарагдах**
- даругасу* – **дараас**
- дарумта* – **дарамт**
- дарумал* – **дармал**
- дарулта* – **даралт**
- даруши* – **дарш** гэх мэт.

Ер нь монгол бичиг сурч, сургаж байгаа хүн үгийн язгуур үндсийг сайн нүдэлж, кирил үсгийн дүрэм шиг үгийн үндсэнд байгаа эгшиг нэг гарч ирээд, нэг алга болж, үг, үеийн бүтцийг байнга эвдэж байдаггүй юм гэдгийг санах учиртай.

Монгол бичигт үгийн язгуур үндсийн хэлбэр бүтэц тогтвортой төдийгүй түүнд залгах дагавар нөхцөл нь чанга хөндий буюу эр эм үгэнд залгах хоёрхон хувилбартай бөгөөд дүр байдлаа үл хувилгана. Жишээ нь, монгол бичгийн «*ᠪᠢᠷᠯᠢᠭ᠎ᠠ*» (-лга, -лгэ) гэсэн дагавар бий.

ᠪᠢᠷᠯᠢᠭ᠎ᠠ (*барилга*) – барилга

ᠡᠮᠨᠢᠭᠡ (*эмнэлгэ*) – эмнэлэг

ᠮᠡᠳᠡᠯᠭᠡ (*мэдэлгэ*) – мэдлэг

ᠪᠣᠳᠤᠯᠭᠠ (*бодулга*) – бодлого

ᠤᠷᠢᠯᠭᠠ (*урилга*) – урилга гэх мэт.

Гэтэл кирил үсгийн дүрэмд -лга⁴, -лаг⁴, -лага⁴ хэлбэртэй, тус бүр дөрвөн хувилбараар бичдэг. Кирил үсэг монгол хэлний үгзүйн онцлогийг монгол бичиг мэт бүрнээ тусгаж чадахгүй олон учир дутагдалтай тул энэ мэт үгийн язгуур, түүнд залгах дагавар, нөхцөлийн хэлбэр бүтэц тогтворгүй, зөв бичих дүрэм нь ч будлиан маргаан ихтэй байдаг.

3. Зөв бичихзүйн гурав дахь зарчим нь түүхэн уламжлалын зарчим бөгөөд энэ нь амьд ярианы хэлний дуудлагыг ямар байхыг харгалзалгүй, зөвхөн уламжлалт бичлэгийг л баримталж бичих ёс юм. Аливаа хэл урт удаан хөгжлийнхөө явцад амьд ярианы хэл, бичгийн хэлний дуудлага хоорондоо тохирохгүй болдог. Үүнийг дагалдаад, уламжлалыг баримтлан бичих үгс буй болдог. Монгол бичгийн зөв бичихзүйд түүхэн уламжлалын зарчим бас нэлээд үүрэгтэй. Энэхүү уламжлалт зарчим гээчийн цаана монгол хэлний түүхэн хувьсал, үгийн гарлын учир шалтгаан, үндэсний хэл сэтгэлгээний тусгал, соёлын өв түүх илэрч байдаг учир уламжлалт бичлэгийг өөрчлөн алдагдуулахгүй байх зарчимтай явсаар иржээ. Монгол бичгийн түүхэн уламжлалаар бичих үгсийг ерөнхийд нь хоёр хуваан үзэж болно.

Нэгдүгээрт, монгол хэлний авианзүйн түүхэн хөгжлийн явцад авианы ижилсэх, ондооших зэрэг харилцан нөлөөлөл, урт хос эгшиг бүрэлдсэн хувьслын үр дүнд орчин цагийн монгол хэлний ярианы дуудлагаас зөрөөтэй бичдэг нэг хэсэг үг бий болжээ. Гэхдээ энэ нь авианзүйн тодорхой зүй тогтол, учир шалтгаан, тогтолцоотой болохыг анхаарах нь зүйтэй юм.

Хоёрдугаарт, бусад улс үндэстэнтэй тогтоосон Монголчуудын түүх, соёл, улс төр, эдийн засаг, шашин шүтлэг зэрэг олон талын харилцааны тусгал болсон ормол үгийг бичихдээ тухайн хэлний дуудлага, бичлэгийг сайтар баримтлан бичдэг байсан тул тийм үгс түүхэн уламжлалаар бичдэг үгсийн нэгэн хэсгийг бүрдүүлдэг. Цаг хугацаа улирах тутам тухайн үг харь хэлний үг гэдэг нь мэдэгдэхгүй болж, зөвхөн бичихдээ л уламжлалаа баримталдаг. Жишээлбэл, агшин (эгшин) гэдэг үгийг монгол бичгээр *ᠠᠭᠰᠢᠨ* - гшан гэж бичдэг, учир нь энэ үг санскрит хэлний кшан гэсэн үг бөгөөд монгол хүн үгийн

эхэнд эгшиггүй давхар гийгүүлэгч хэлж чаддаггүй тул а, э эгшиг үгийн тэргүүнд нэмэн агшин, эгшин гэж дууддаг бөгөөд бичихдээ санскрит бичлэгийг баримталдаг ажээ.

4. Дээрх зөв бичихзүйн түүхэн уламжлалын зарчмаас үүдэн гарсан бэлгэ тэмдгийн буюу дүрсээр ялган бичих зарчим гэж буй. Амьд ярианы хэлний хөгжил, хувьслын дүнд эрт цагт өөр өөрөөр дуудаж, хэлж байсан үг орчин цагийн монгол хэлэнд адил дуудлагатай болжээ. Гэтэл бичигт тухайн үгсийг эртний дуудлага, бичлэгээр нь бичих тул адил дуудлагатай, бичлэг ондоотой, утга өөр үгс буй болсон байна. Тухайлбал, эртний монгол хэлэнд *ᠠᠨᠠᠯᠠᠭ* - дагулаху (*дуу дуулах*), *ᠠᠨᠠᠯᠠᠭᠤ* - дугулху (*сураг чимээ дуулах*) гэсэн дуудлага, бичлэг, утга аль аль нь өөр үг байсан бол орчин цагийн монгол хэлэнд дуудлага нь ижил болжээ. Нэгэн зүйлийг тэмдэглэхэд, эртний монгол хэлэнд дуудлага бичлэг нь ижил, утга өөр үгс байгаагүй мэтээр ойлговол ташаарал болох бөгөөд наад захын жишээ хэлэхэд, эртний болоод орчин цагийн монгол хэл алинд ч ой модны ой, нас жилийн ой, оюун ухааны ойг ялгалгүй бичиж, дууддаг билээ. Мөн монгол бичгийн үсгийн дүрмийн толь зохиосон хожмын бичгийн хүмүүс, үгсийн салаа утгыг зориуд ялган бичсэн тал ч бий.

Өмнө өгүүлсэн дөрвөн зарчмыг товчилбоос, ярианы дуудла-гын дагуу бичихийг авиазүйн зарчим, дуудлагыг харгалзавч үгийн бүтцийг эвдэхгүй бичихийг үгзүйн зарчим, зөвхөн уламжлалт бичлэгийг дагахыг түүхэн уламжлалын зарчим, ижил дуудлага-тай, салаа утгатай үгийг ялган бичихийг бэлгэ тэмдгийн зарчим гэдэг билээ.

❖ Монгол бичгийн цагаан толгой ба үсэгзүй

Монгол бичгийн цагаан толгой нь 30 үсэгтэй бөгөөд 7 эгшиг, 23 гийгүүлэгч (уугуул монгол үгэнд ордог 16 гийгүүлэгч, харь хэлний үгийг тэмдэглэх 7 галиг) үсгээс бүрдэнэ.

Монгол бичгээр бичихэд тулгуур болдог зурлага бол эгшиг үсгийн үндсэн махбодууд болно.

Монгол бичгийн үсгийн үндсэн зурлага			
ᠠ	титэм (<i>эрүү</i>)	ᠡ	шилбэ (<i>урт шүд</i>)
ᠢ	шүд (<i>өргөс, ацаг</i>)	ᠣ	нум (<i>хумс</i>)
ᠣ	сүүл	ᠤ	гэдэс
ᠤ	орхиц (<i>цацлага, хаялга</i>)	ᠮ	нуруу (<i>холбоос, гол</i>)

1. Эгшиг

Эгшиг үсэг	А	Э	И	О	У	Ө	Ү
Үгийн эхэнд	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠤ	ᠥ	ᠦ
Үгийн дунд	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠤ	ᠥ	ᠦ
Үгийн адагт	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠤ	ᠥ	ᠦ

- А, Э эгшгийг үгийн дунд, адагт ижил хэлбэртэй бичдэг. Үгийн адагт орох «ᠠ» хэлбэрийг гийгүүлэгчийн дараа залгаж бичих бөгөөд «ᠡ» хэлбэрийг гийгүүлэгчээс салангид болон залгаж бичдэг.

Жишээ нь: **ᠠ** -энэ (энэ), **ᠡ** -тэрэ (тэр),
ᠠᠬ -ах-а (ах), **ᠠᠳᠡᠭᠦᠷ** -дэгэр-э (дээр),
ᠰᠠᠪ -саба (сава), **ᠠᠳᠡᠭᠦ** -тэргэ (тэргэ) гэх мэт.

- Ө, Ү эгшгийн үгийн дундах «ᠥ» хэлбэрийг үгийн тэргүүн үед гийгүүлэгчийн дараа бичнэ.

Жишээ нь: **ᠬᠦᠮᠦᠨ** -хүмүн (хүн), **ᠲᠦᠭᠦᠷᠦᠨᠭ** -дүгүрэнг (дүүрэн)
ᠨᠥᠬᠦᠷ -нөхөр (нөхөр), **ᠮᠥᠨᠭᠬᠡ** -мөнгхэ (мөнх) гэх мэт.

2. Гийгүүлэгч

	На, Нэ	Ни	Но, Ну	Нө, Нү
Үгийн эхэнд	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ
Үгийн дунд	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ
Үгийн адагт	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ

	Ма, Мэ	Ми	Мо, Му	Мө, Мү
Үгийн эхэнд	ᠮ	ᠮ	ᠮ	ᠮ

Үгийн дунд	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ
Үгийн адагт	ᠨ	ᠨᠦ	ᠨᠦ	ᠨᠦ	ᠨᠦ

	Ла, Лэ	Ли	Ло, Лу	Лө, Лү
Үгийн эхэнд	ᠯ	ᠯ	ᠯ	ᠯ
Үгийн дунд	ᠯ	ᠯ	ᠯ	ᠯ
Үгийн адагт	ᠯ	ᠯᠦ	ᠯᠦ	ᠯᠦ

- **Н** гийгүүлэгчийг эгшгийн өмнө цэгтэй «ᠨ · ᠯ», гийгүүлэгчийн өмнө болон үгийн адагт цэггүй «ᠨ · ᠯ» бичнэ.
Жишээ нь: ᠮᠠᠨᠠᠨ – манан, ᠦᠨᠦ – үнэ;
ᠮᠠᠨᠵᠠ – маңдай, ᠨ – он гэх мэт.
- «ᠯ» үсгийг гийгүүлэгчийн дараа орвол **А**, **Э**-ээр, эгшгийн дараа орвол **Н**-ээр уншина. Үүнийг монгол хэлний үеийн тогтолцоогоор бодвол илэрхий болно.
Жишээ нь: ᠮᠠᠯᠯᠠ (малла), ᠦᠨᠦᠨ (үнэн) гэх мэт.
- Монгол бичигт хэлний урдуур, хойгуур хэлэгдэх **Н** авиаг тус тусад нь тэмдэглэдэг. Хэлний урдуур хэлэгдэх «ᠨ · ᠯ» хэлбэрийг бага энхлэг гэх бөгөөд хэлний хойгуур хэлэгдэх «ᠨ · ᠯᠦ» хэлбэрийг их энхлэг гэдэг.

	Ба, Бэ	Би	Бо, Бу	Бө, Бү
Үгийн эхэнд	ᠪ	ᠪ	ᠪ	ᠪ
Үгийн дунд	ᠪ	ᠪ	ᠪ	ᠪ
Үгийн адагт	ᠪ	ᠪᠦ	ᠪᠦ	ᠪᠦ

	Х		Ха	Хэ	Хи	Хо, Ху	Хө, Хү
	эр	эм					
Үгийн эхэнд	ᠬ	ᠬ	ᠬ	ᠬ	ᠬ	ᠬ	ᠬ

Үгийн дунд	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠤ	ᠥ	ᠦ
Үгийн адагт		:	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠦ

	Г		Га	Гэ	Ги	Го, Гу	Гө, Гү
	эр	эм					
Үгийн эхэнд	ᠭ	ᠮ	ᠭ᠎	ᠭᠡ	ᠭᠢ	ᠭᠣ, ᠭᠤ	ᠭᠦ, ᠭᠦ
Үгийн дунд	ᠭᠠ	ᠭᠡ	ᠭᠢ	ᠭᠣ	ᠭᠤ	ᠭᠦ	ᠭᠦ
Үгийн адагт	ᠭ	ᠮ	ᠭᠠ	ᠭᠡ	ᠭᠢ	ᠭᠣ	ᠭᠦ

		Жа, Жэ, За, Зэ	Жи, Зи	Жо, Жу, Зо, Зу	Жө, Жү, Зө, Зү
Үгийн эхэнд	ᠵ	ᠵᠠ	ᠵᠢ	ᠵᠣ	ᠵᠦ
Үгийн дунд	ᠵ	ᠵᠠ	ᠵᠢ	ᠵᠣ	ᠵᠦ
Үгийн адагт	:	ᠵᠠ	ᠵᠢ	ᠵᠣ	ᠵᠦ

		йа, йэ	йи	йо, йу	йө, йү
Үгийн эхэнд	ᠶ	ᠶᠠ	ᠶᠢ	ᠶᠣ	ᠶᠦ
Үгийн дунд	ᠶ	ᠶᠠ	ᠶᠢ	ᠶᠣ	ᠶᠦ
Үгийн адагт	ᠶ	ᠶᠠ	ᠶᠢ	ᠶᠣ	ᠶᠦ

- Үгийн дунд **Й** (у) гийгүүлэгчийн эртгэртэй шилбэ «ᠶ» хэл-бэрийг **И**-ээс бусад эгшгийн өмнө голдуу бичих ба эртгэргүй шилбэ «ᠶ» хэлбэрийг **И** эгшгийн өмнө бичнэ.

Жишээ нь: **ᠶᠠᠨᠭᠠ** -уянга (уянга), **ᠶᠤᠲᠠᠨ** -оютан (оютан),
ᠶᠠᠶᠢᠨ -сайн (сайн), **ᠪᠠᠶᠢᠨ** -байн (байн) гэх мэт.

	Т	Д	Та, Тэ, Да, Дэ	Ти, Ди	То, Ту, До, Ду	Тө, Тү, Дө, Дү
Үгийн эхэнд	ᠲ	ᠳ	ᠲ᠎	ᠲᠢ	ᠲᠣ	ᠲᠦ
Үгийн дунд	ᠲ	ᠲᠦ	ᠲᠦ	ᠲᠢ	ᠲᠦ	ᠲᠦ
Үгийн адагт	:	ᠳᠦ	ᠲᠦ	ᠲᠦ	ᠲᠦ	ᠲᠦ

- Үгийн дунд, адагт тохиолдох Д нь тус бүр хоёр хэлбэртэй. Үгийн дунд эгшгийн өмнө «ᠲ» хэлбэрийг, гийгүүлэгчийн өмнө «ᠲᠦ» хэлбэрийг бичдэг. Үгийн адагт дэвсгэрлэж орсон Д гийгүүлэгчийг «ᠲᠦ» хэлбэрээр бичих бөгөөд уламжлалт бичлэгтэй хэдхэн үгэнд «ᠲ» хэлбэрийг бичдэг.

